



22110203



International Baccalaureate®
Baccalauréat International
Bachillerato Internacional

MONGOLIAN A1 – STANDARD LEVEL – PAPER 1
MONGOL A1 – NIVEAU MOYEN – ÉPREUVE 1
MONGOL A1 – NIVEL MEDIO – PRUEBA 1

Wednesday 11 May 2011 (morning)

Mercredi 11 mai 2011 (matin)

Miércoles 11 de mayo de 2011 (mañana)

1 hour 30 minutes / 1 heure 30 minutes / 1 hora 30 minutos

INSTRUCTIONS TO CANDIDATES

- Do not open this examination paper until instructed to do so.
- Write a commentary on one passage only. It is not compulsory for you to respond directly to the guiding questions provided. However, you may use them if you wish.

INSTRUCTIONS DESTINÉES AUX CANDIDATS

- N'ouvrez pas cette épreuve avant d'y être autorisé(e).
- Rédigez un commentaire sur un seul des passages. Le commentaire ne doit pas nécessairement répondre aux questions d'orientation fournies. Vous pouvez toutefois les utiliser si vous le désirez.

INSTRUCCIONES PARA LOS ALUMNOS

- No abra esta prueba hasta que se lo autoricen.
- Escriba un comentario sobre un solo fragmento. No es obligatorio responder directamente a las preguntas que se ofrecen a modo de guía. Sin embargo, puede usarlas si lo desea.

Доорх хоёр зохиолын аль нэгийг сонгон тайлбарлаж бич.

1.

Хангинасан жавартай жигтэй хүйтэн өдөр, битүү цастай ар тал газар бэлчсэн адууны хөл цасанд далд орж хонь шиг намхан харагдаж байв. Жавхлант өндөр, Алтайн хяр буданд бүрхэгдэж, дах нөмөрсөн аварга эр шиг сүндэрлэж байлаа. Үдэш болов. Цалмахмид өвгөний мал хотондоо ирээд хашаалахын завсар хонид нь 5 бээрсэн хөлөө өэлжлэн өргөж, үхэр эврээ сэжлэн дэмий холхиод, дахлай ишиг үүд нөмрөн гэр лүү шургаж, хүн малын хөлд цас чахнаж байлаа. Үдшийн гэгээ тасарч жавар намжаад нарийн ширхэгтэй цас нягтран орж эхлэв. Хээр холд манаачин хүний хашгираас өөр гойд чимээгүй.

Хүн мал дулаан хэвтэртээ дугжран унтаж байлаа. Гагцхүү Цалмахмидын 10 нойр хулжиж, зудаас зайллан нүүх тухай мэдээ сумнаас ирэхийг тэсгэлгүй хүлээж хэвттэл морио давирсан хүн гадаа айсуй. Тэр хүнийг нохой айхавтар хоргоов. Өөхөн дэнгийн гэрэлд ирсэн хүний нүүр байдал тодорхой харагдана. Хичээнгүй төлөвтэй залуухан хүн ажээ. Халаасан цай уух завсар сумын захиргааны захиа зааврыг өвгөн Цалмахмидэд хэлээд, бусад айлд мэдээ хүргэх гэж яаран мордов.

15 Цалмахмид гавшгай хөдөлж, хүүхэд гүйлгэж айл хөршийн эрэгтэйчүүдийг цуглуулаад, хүсэн хүлээсэн хэрэг бүтсэний тухай Ханзарваан ах дүү таван айлд мэдэгдэхээр нэгэн хүнийг мордуулав.

Бусдыг нь “Одоо шамдагтун! Тэнгэрийн байдал цас орохoo зогсох шиг, маргаашийг хүлээхгүй хөдлөө” гэв. Хот айл үймэлдэн хөдөлж хом ширдэг, 20 аргамж дээс зэхэж, буйл бурантаг барьсан хүн гүйлдэв. Хамраа бурантаглуулсан тэмээдийн дуу, дутуу сэргэн хүүхдийн уйлах, унь, хана шажигнах чимээ, хүний нарийн бүдүүн дуу холилдон сонсдоно. Энэ нэгэн хот айл их нүүдэлд бэлтгэв. Удалгүй ачаалсан гэрийн бууцан дээр гал дүрэлзэн, хүн бүхэн яаралтай хөдлөв.

25 Цалмахмид шар шувууны өдөн залаатай хар хурган малгайгаа өмсөж мордоод, анч бүргэдээ бүүргэн дээрээ суулгаж, цахиур бууны дор цалам /бугуйл/ мөрөвчлөөд шөнийн түүдэг галыг сонирхож үе үе аргалын утаа амьсгалж байгаа сүрэг адууг хөдөлгөж, бусад малдаа зам гаргаж өгөх гэж туулаа.

Хонь, үхэр харанхуй шөнө дулаан хэвтрээсээ босох дургүй. Айлынхан хүүхэд шуухадтайгаа хамтран, чүү чамай босгож туув. Хонь хар цагааны зааг дээр 30 хүрээд тойрон эргэлдэж, бөөрөөрөө чихэлдэн гэдрэг түрээд, бяруу тугал мөөрөлдөн гүйлдэж, галын дэргэд буцаж ирж байлаа. Хүүхэд цасан дотор унан тусан хүн бүгд цөхөн ядан байтал шөнө дунд өнгөрчээ. Цалмахмид задгай гал дээр цас хаян унтрааж, хэдэн хүнд хоёр хоёр хонь хөтлүүлэн явуулаад хойноос нь хэдэн хүн хамжиж, цөөхөн хонь таслан туулаа. Тэгэн тэгсээр мал замд ороод, 35 аян шуудрав. Хашир малчин Цалмахмид адууны замаар тэмээтэй ачаагаа оруулаад, хойноос нь үхрээ, хамгийн сүүлд хонио туув.

Цас орохoo зогсоод, үүр гэгээрч байвч бүрхэг будантай байв. Алс хол 40 өгссөн Зүйлд гэдэг хавцлын харгуй зам, хайр чулуу харгана эмээлжийг цас дарж, тойм нь мэдэгдэхгүй болжээ. Битүү цас адууны гэдэс шүүрч, орой гарсан унага эхийн мөрөөр ороод эвгүй газар арай ядан гишгэлж явах нь хөөрхийлөлтэй. Хүүхэд даарсан нүүрээ хааяа дээлийн ханцуугаар шударч яваа харагдана. Уйлсан нярай хүүхдийг эх нь тохитой хөхүүлж чадахгүй, багагүй чармайж явсаар тэнгэр цэлмэж, үдийн нар илч муутай гялтганахыг үзлээ. Хүйтэн жавар нүүрэнд наалдаж, хоргодож хономоор аятай газар тохиолдохгүй байлаа. Буурал толгойтой

45 анчин бүргэд хол ойрыг шуналтай харж, шонхолзон өрвөгнөн явснаа гэнэт жигүүр дэлгэн догширч, муухай хяхнан хагшив. Үзвэл баруун гарг зэргэлдээ байгаа хамар өөд нэг чоно авирч явав. Цалмахмид “Ганц болов уу, олон бол бүргэдийг минь урчихна шүү” гэж устсан нүдээ арчин арчин ажиглаад, бүргэдийн хошуувчийг мултлахад бүргэд хүйтэн агаарт хоёр гурав эргэлдэн эрчилж, сандарсан чонын эгц 50 дээрээс нь далавчaa хумин дайрав.

Бүргэдийн нисэхийг хараад, Цалмахмидийн унасан хул морь баас хаяж, гэдсээ хөнгөвчлөн, давхихад бэлтгэж байв. Тэгээд Цалмахмид түрүүлэн олон хүн давхилдан очиход бүргэд хурц хумсаараа чонын толгойг өм базаад, өрөөсөн савраараа ургаа хаданд торолдон тогтох, чоныг сарвайтал чангааж суув. 55 Нүүдэлчин, дайсныг дарав гэж баярлацаахад нь Цалмахмид өвгөн “өдийд өлөгчин чоно ганцаараа явахгүй. Үүнд хань бий. Болгоомжлох хэрэгтэй” гэж бусад нөхөддөө сануулав. Наран үд хэлбийв. Нүүдэлчин урагшлан явтал өмнө нь асга чулуутай энгэрт өндөр иштэй ерхөг шарилж нүдэнд бүлээн үзэгдэв. Бэлд нь бууц баймаар газар цасан доороос хашааны шон ёрдойн үзэгдэв. Цалмахмид урьдаас 60 бодсон энэ газар хонохоор шийдвэрлэж түрүүлэн явахад хойноос нь тэмэр хүрз барьсан эрэгтэйчүүд давхилдан очиж буух газрын цасыг малтав. Их багагүй тэр тийш хандав. Удалгүй хатгуур овоохой гэрүүд босч, утаа баагив. Нүүдэлчин, унасан морийг тушиж, ачсан тэмээдийг сойжээ. Бууцын баруун талбай дээр сурамгай адуу цас цавчилж, борог өвсийг гарган иднэ.

М Бизъяа, Өвлийн нүүдэл (1945)

- Зохиолын хэсэгт уран дүрслэлийн ямар арга хэрэглүүр ашигласныг тайлбарла.
- Уг найруулал дахь байгалийн дүрслэлийн онцлогийг тайлбарла.
- Монгол нүүдэлчин ахуйтай холбогдох уг хэллэгийн найруулгын үүрэг, ач холбогдлыг тайлбарлан бич.

2.

- Дэвхрэг царцаа хүртэл
 Дээгүүр доогуур цовхорч
 Дэлэнч шумуул ч гэсэн
 Дэргэд ирээд наадна.
- 5 Зуны шар наран
 Зулай дээрээс төөнөнө.
 Зураг шиг сайхан хангай
 Зугаалж амрахыг урина.
 Өндөр гоолиг улиасны
- 10 Өчүүхэн намхан бургаасны
 Навч нахия шивнэлдэж
 Нарны халхавч болно.
 Загас жараахай уралдан
 Усан дундаа булгиж
- 15 Зочин бидэнд сонирхуулж
 Уран бүжгээ үзүүлнэ.
 Эгийн голын минь сайхныг
 Энхрий нутгийн минь үзэсгэлэнг
 Эхнэр хүүхэд маань үзэж
- 20 Элэг зүрхнээсээ биширч
 Байгалийн сайханд умбаж
 Бие сэтгэл нь сэргэж
 Энэ тэрийг шалгааж
 Эрэг даган алхална.
- 25 Аян замын танил
 Авто машины жолооч
 Танай нутаг үнэхээр
 Тун сайхан газар шүү.
 Эгийн голын захад
- 30 Ирээд хэсэг зогсоход
 Бие сэтгэл сэргэж
 Бяр тэнхээ нэмэгдэж
 Ядаргаа арилдаг юм гэж
 Ярьж байхыг сонсоод
- 35 Ханагар уудам орныхоо
 Хaa ч явсан тэр
 Нутаг усандаа монгол хүн
 Нүдний цөцгий шигээ хайртайг
 Зүрх сэтгэлээрээ мэдэрнэм.
- 40 Зүйтэй хэмээн бахарханам.

Г Ядамсүрэн, Бярвааз (1978)

- Шүлгийн хэсгийн хэл найруулгын онцлогийг тайлбарлан бич.
 - Шүлгийн хэсгийн утга санааг илэрхийлэхэд жолоочийн дүр ямар үүрэгтэй байна вэ?
 - Шүлгийн хэсгийн бүтцийн онцлог тал нь юу вэ?
-